

ГЭРЛЭЛТ ЦАГААЧЛАГЧИЙН ЭЦЭГ ЭХ, ГЭР БҮЛ (F-1-5)

ОЛГОХ ХҮРЭЭ:

• Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх дэмжлэг (жирэмсэн эсвэл асрах)

Гэрлэлт цагаачлагч, Солонгос эхнэр/нөхөр нь жирэмсэн болон асаргаа шаардлагатай бага насны хүүхэд өгсөн хүмүүжүүлж байгаа тохиолдолд БНСУ-д зорчих виз мэдүүлсэн өдрөөс тооцож, хүүхэд 9 нас хүрэх оны 9-р сарын сүүл хүртэл урих боломжтой. (1 хүүхэд тус бүр дээр 1 хүн урих боломжтой, эцэг эх хамт эсвэл дараалуулан нийт 2 удаа урьж болно), урих тоо хязгааргүй.)

Нөхцөл

• Өрх толгойлсон эцэг, эх эсвэл олон хүүхэдтэй гэр бүл (3 ба түүнээс дээш насанд хүрээгүй хүүхэд)

Виз мэдүүлсэн өдрөөс тооцож, хүүхэд 12 нас хүрэх оны 9-р сарын сүүл хүртэл урих боломжтой. (1 хүүхэд тус бүр дээр 1 хүн урих боломжтой (эцэг эхээ хамтад нь дараалуулан урьж болно), урих тоо хязгааргүй)

Уригдагч

1. Гэрлэлт цагаачлагчийн эцэг, эх
2. Гэрлэлт цагаачлагчийн эцэг, эх нь хоёулаа нас барсан эсвэл өвчтэй, өндөр настай зэрэг зайлшгүй шалтгаанаар БНСУ-д зорчих боломжгүй тохиолдолд тус улсын “Иргэний хууль”-д зааснаар насанд хүрсэн төрсөн ах, эгч, дүү болон өмнөх гэрлэлтээс төрсөн хүүхэд. * Зөвхөн төрсөн ах, эгч, дүү болон өмнөх гэрлэлтээс төрсөн хүүхэд нь өөрөө насанд хүрээгүй хүүхэдгүй тохиолдолд урих боломжтой.

※ Хүүхэд сургуульд сурах үүргийг биелүүлээгүй тохиолдолд урих эрх хязгаарлагдана

- Сургуулийн насны хүүхэдтэй боловч, уригч тал хүүхдээ сургуульд сургах үүргээ биелүүлээгүй бол Монгол дахь гэр бүлээ урих боломжгүй.
- Зөвхөн өвчин зэрэг зайлшгүй шалтгааны улмаас хүүхэд бага сургуульд орох эсвэл анги дэвших нь хойшлогдсон тохиолдолд, **урих нас нь хэтэрсэн ч бага сургуулийн 3-р ангийн 9 дүгээр сарын сүүл (энгийн нөхцөл) эсвэл 6-р ангийн 9 дүгээр сарын сүүл(өрх толгойлсон эцэг эх, олон хүүхэдтэй гэр бүл) хүртэлх хугацаанд урих боломжтой.**

ВИЗНИЙ ТӨРӨЛ (хүчинтэй хугацаа/ оршин суух хугацаа): Богино хугацааны виз(S): 3 сар/90хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/Хуулбар 1 хувь
3. Хөдөлмөр эрхлэхгүй тухай амлалт бичиг

4. Гэрлэлт цагаачлагчийн гэр бүлийн холбоо хамаарлын лавлагаа

- Эцэг, эх
 - ▣ Төрсний бүртгэлийн лавлагаа, үрчилэлтийн гэрчилгээ(үрчилсэн эцэг, эх), гэрлэлт бүртгэлийн лавлагаа, лавлагаа тус бүрийг E-Mongolia -аас авсан байх
 - ▣ Гэр бүлийн зураг
- Төрсөн ах, эгч, дүү
 - ▣ Гэрлэлт цагаачлагчийн төрсний бүртгэлийн лавлагаа, уригдагчийн төрсний бүртгэлийн лавлагаа, гэрлэлт бүртгэлийн лавлагаа, лавлагаа тус бүрийг E-Mongolia-аас авсан байх.
 - ▣ Гэр бүлийн зураг
- Өмнөх гэрлэлтээс төрсөн хүүхдэд
 - ▣ Төрсний бүртгэлийн лавлагааг, лавлагаа тус бүрийг E-Mongolia-аас авсан байх.
 - ▣ Гэр бүлийн зураг * Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох шаардлагатай тохиолдолд ДНХ-н шинжилгээний хариуг нэмэлтээр шаардана.

5. Эцэг эх нь БНСУ-д зорчих боломжгүй шалтгаан болон нотлох бичиг баримт (Холбогдох хүн)

- 60 ба түүнээс дээш өндөр настай шалтгааны улмаас нэвтрэх боломжгүй тохиолдолд түүнийг нотлох бичиг баримт
- Өвчтэй эсвэл нас барсан эсэхийг гэрчлэх бичиг баримт (ЭСЯ-аас заасан эмнэлгийн тодорхойлолт)
* ЭСЯ-наас заасан Монгол эмнэлэг: Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын 1, 2, 3-р эмнэлэг, Интермед эмнэлэг, Грандмед эмнэлэг, УБ Сонгдо эмнэлэг

6. Сүрьеэгийн оношилгооны хуудас (ЭСЯ-наас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2)

※ Өмнө нь уригч талаас урилга аваад БНСУ-д нэвтэрсэн гадаад иргэдийн хувьд тус улсын “Хилийн шалган нэвтрүүлэх тухай хууль”-н дагуу хилээр гаргах тушаал эсвэл албадан гаргах тушаал авч байгаагүй байх ёстой.

УРИГЧ ТАЛ БҮРДҮҮЛЭХ

1. Иргэний үнэмлэхийн хуулбар

2. Урилга (Эх хувь)

- Батлан даалтын бичиг(батлан даах хугацаа: БНСУ-ын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлээд 3 жил)
- Хууль бусаар оршин сууж/ажил хийхгүй байх амлалт бичиг

3. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт(сүүлийн 3 сарын дотор авсан байх)

- Үндсэн мэдээллийн лавлагаа, ам бүлийн тодорхойлолт, гэрлэлт бүртгэлийн лавлагаа, иргэний бүртгэлийн лавлагаа, хүүхдийн нэр дээрх ам бүлийн тодорхойлолт

※ Жирэмсэн тохиолдолд эмнэлгийн тодорхойлолт эсвэл жирэмсэн эхийн эрүүл мэндийн дэвтэр

※ Хоёр болон түүнээс дээш хүүхэдтэй тохиолдолд хүүхэд тус бүрийн нэр дээрх ам бүлийн тодорхойлолт, үрчилэн авсан тодорхойлолт, үрчилж авсныг нотлох бичиг баримтыг нэмэлтээр өгнө.

4. Оршин суух газрыг нотлох бичиг баримт (үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, түрээсийн гэрээний хуулбар)

5. Сургуулийн насны хүүхэд байх тохиолдолд сургуулийн тодорхойлолт (холбогдох хүн)

6. Хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох бичиг баримт (холбогдох хүн)

- “Хүнд өвчин/эдгэшгүй өвчин” эсвэл “Улсын онцгой тэтгэмж” авсан нь үнэн болохыг нотлох эмчийн төлбөрийн баримт гэх мэт
- “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл” эсвэл “Хүндэвтэр хөгжлийн бэрхшээл”-тэй гэж тэмдэглэгдсэн тохиолдолд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй гэж үзнэ.

※ Хүнд өвчин болон хөгжлийн бэрхшээл

- Гэрлэлт цагаачлагч, Солонгос эхнэр/нөхөр, хүүхэд дундаас аль нэг нь хүнд өвчинтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй байх тохиолдолд
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх” дээр “Хөгжлийн бэрхшээлийн ерөнхий хэмжээ” гэсэн хэсэгт “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл” эсвэл “Хүндэвтэр хөгжлийн бэрхшээл”- тэй гэж тэмдэглэгдсэн тохиолдолд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй гэж үзнэ.

- **Уригч тал нь гэрлэлт цагаачлалаар оршин суухаар бүртгэгдсэн гадаад иргэн байх тохиолдолд:** Солонгос эхнэр/нөхөр нь шаардагдах бичиг баримтыг өгнө.
- **Уригч тал нь өрх толгойлсон эцэг/эх бол:** Хүүхдийн нэр дээрх үндсэн мэдээллийн лавлагаа, ам бүлийн тодорхойлолт, иргэний бүртгэлийн лавлагаа, өмнөх эхнэр/ нөхрийн гэрлэлт бүртгэлийн лавлагаа

※ Уригч эсвэл уригчийн урилгаар ирсэн гадаадын иргэн нь БНСУ-ын хууль журмыг зөрчиж байсан тохиолдолд хэрэг хаагдсан өдрөөс хойш 5 жил өнгөрсний дараа Монгол дахь гэр бүлээ урих боломжтой бөгөөд дээр дурдсан хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд 1 жилийн дараа урих боломжтой.